



ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 12

Мандалговь

Амьжиргаа дэмжих зөвлөлийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.14, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.3 дахь хэсгүүдийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Сумын "Амьжиргаа дэмжих зөвлөл" -ийг дараахи бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд :

А. Зөвлөлийн дарга : 1. И. Эрдэнэцог (Засаг даргын орлогч)

Б. Нарийн бичгийн дарга: 2. Ч. Сэржмядаг (сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

В. Гишүүд : 3. Б. Батзориг (сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

4. Б. Оюунмаа (Төрийн бус байгууллагын төлөөлөл)

5. Д. Дэлгэрмаа (Төрийн бус байгууллагын төлөөлөл)

6. Б. Мөнхчулуун (Иргэний төлөөлөл)

7. Ж. Уртнасан (Иргэний төлөөлөл)

2. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/89 тоот тушаалаар батлагдсан Амьжиргаа дэмжих зөвлөлийн дүрмийг мөрдлөг болгон ажиллахыг тус зөвлөлд үүрэг болгосугай.

3. Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6-д заасны дагуу зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Б. Эрдэнэтуяа)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Сайнцагаан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 06 сарын 27-ны өдрийн 31 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Т. БАТЖАРГАЛ